



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Нисгэгчгүй нисэх төхөөрөмж ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдуулан мэргэжлийн байгууллага болон сонирхогчийн үйл ажиллагаанд дрон ашиглах зориулалтаар туршилтын бүсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нийслэлийн Баянзүрх, Налайх дүүрэг болон Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт байгуулах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд, дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг), Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), холбогдох Засаг дарга нарт даалгасугай.

2. Туршилтын бүсэд мөрдөх нислэгийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, стандартыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас баталсан стандарт, шаардлагад нийцүүлэн баталж, мөрдүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд даалгасугай.

3. Туршилтын бүсийн үйл ажиллагаа болон шинээр бүс байгуулах судалгаанд шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө багтаан, санхүүжүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД

ШТА:206 0023100394 5498449

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ц.БААТАРХҮҮ